



**АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139

Утас/Факс: (976) 7033 3231,

Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,

Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2024.03.07 № 03/331

танай _____-ны № _____-т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ**

Архангай аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэн, 2023 оны 1 дүгээр улиралтай харьцуулсан тайлан мэдээг хүргүүлж байна.


Хавсралт 5 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  ДАЛТАНГЭРЭЛ



6524.000 Bqs A5 D N 7

Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын
2024 оны 03 дугаар сарын 02 ны өдрийн
03/331 дүгээр албан бичгийн хавсралт



2024 оны 1 дүгээр улиралын байдлаар

| Байгууллагын нэр | Өргөдөл гомдлын төрөл | | | | Хүлээн авсан хэлбэр | | | | |
|-----------------------------------|-----------------------|------------|-----------|-------------|---------------------|------------|------------|-------------------------|---------------|
| | Мэдэгдэл | Гомдол | Санал | Хүсэлт | Биеэр | Утсаар | Цахимаар | 11-11 төвөөс шилжүүлсэн | Албан бичгээр |
| | 1 | 2 | | 3 | 4 | | | | 5 |
| Аймгийн Засаг даргын тамгын газар | - | 2 | - | 22 | - | - | - | - | 24 |
| Агентлагууд | 1 | 23 | 8 | 296 | 211 | 2 | 14 | 13 | 88 |
| Сумдын Засаг даргын Тамгын газар | 295 | 198 | 15 | 1467 | 931 | 270 | 118 | 11 | 645 |
| Нийт | 296 | 223 | 23 | 1785 | 1142 | 272 | 132 | 24 | 757 |

2023 оны 1 дүгээр улиралтай харьцуулсан дүн

| Байгууллагын нэр | Өргөдөл гомдлын төрөл | | | | Хүлээн авсан хэлбэр | | | | |
|-----------------------------------|-----------------------|------------|------------|-------------|---------------------|------------|------------|-------------------------|---------------|
| | Мэдэгдэл | Гомдол | Санал | Хүсэлт | Биеэр | Утсаар | Цахимаар | 11-11 төвөөс шилжүүлсэн | Албан бичгээр |
| | 1 | 2 | | 3 | 4 | | | | 5 |
| Аймгийн Засаг даргын тамгын газар | - | 2 | - | 75 | - | - | - | - | 77 |
| Агентлагууд | - | 362 | 279 | 1221 | 656 | 557 | 82 | - | 567 |
| Сумдын Засаг даргын Тамгын газар | - | 126 | 98 | 2640 | 53 | 46 | 238 | - | 2527 |
| Нийт | - | 488 | 377 | 3938 | 709 | 603 | 320 | - | 3171 |

2024 оны 1 дүгээр улиралын байдлаар

| Шийдвэрлэлтийн байдал | | | | | | | | | | |
|-----------------------------------|---------------|-----------|------------|------------|---------------------------------|---|---|---|------------------|----------------------|
| Шийдвэрлэж хариу өгсөн | | | | | Бусад байгууллагад шилжүүлсэн | | Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/ | Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/ | Хугацаа болоогүй | Шийдвэрлэх боломжгүй |
| Байгууллага | Албан бичгээр | Цахимаар | Утсаар | Биечлэн | Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо | | | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Аймгийн Засаг даргын тамгын газар | 9 | - | 1 | 1 | 3 | - | - | - | 10 | - |
| Агентлагууд | 112 | 13 | 24 | 125 | 6 | - | - | - | 48 | - |
| Сумдын Засаг даргын Тамгын газар | 918 | 54 | 230 | 735 | 3 | - | - | - | 33 | 2 |
| Нийт | 1039 | 67 | 255 | 861 | 12 | - | - | - | 91 | 2 |

2023 оны 1 дүгээр улиралтай харьцуулсан дүн

| Шийдвэрлэлтийн байдал | | | | | | | | | | |
|-----------------------------------|---------------|------------|------------|----------|---------------------------------|---|---|---|------------------|----------------------|
| Шийдвэрлэж хариу өгсөн | | | | | Бусад байгууллагад шилжүүлсэн | | Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/ | Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/ | Хугацаа болоогүй | Шийдвэрлэх боломжгүй |
| Байгууллага | Албан бичгээр | Цахимаар | Утсаар | Биечлэн | Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо | | | | |
| | 1 | 2 | 3 | 4 | | | | | | |
| Аймгийн Засаг даргын тамгын газар | 5 | 15 | 39 | - | 3 | - | - | - | 15 | - |
| Агентлагууд | 1510 | 278 | 25 | - | 11 | - | - | - | 38 | - |
| Сумдын Засаг даргын Тамгын газар | 1998 | 266 | 457 | - | 17 | - | - | - | 126 | - |
| Нийт | 3513 | 559 | 521 | - | 31 | - | - | - | 179 | - |

| Д/д | Байгууллага | Гомдлын агуулга | тоо | хувь | Өргөдөл, гомдлыг бууруулахад цаашид авах арга хэмжээний санал |
|-----|---|---|-----|-------|--|
| 1. | Эрдэнэмандал, Хайрхан, Хангай, Цэцэрлэг, Цэнхэр, Эрдэнэбулган | Сумдын цас, зудны асуудлаар, зам гаргуулах тухай | 170 | 76.2% | Байгалийн давагдашгүй хүчинд өртсөн |
| 2. | Эрдэнэбулган сум | Газрын маргаантай болон газар шийдвэрлүүлэхтэй холбоотой | 27 | 12.1% | Иргэдийн газрын асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг тухай бүр нь шийдвэрлэж, түргэн шуурхай үйлчлэх |
| | | Гахай устгалтай холбоотой | 1 | 0.4% | Гайхан мялзан өвчинтэй гарсантай холбогдуулан устгал хийсэн |
| 3. | ГХБХБГазар | Засгийн газрын /Иргэд олон нийттэй харилцах 1111 төв/-өөс | 3 | 1.3% | Сумдын газар олголт, газар зохион байгуулалтын талаар чиглэл өгч ажиллах |
| | | Захирамж хүчингүй болгуулах тухай | 1 | 0.4% | - |
| | | Газар шийдвэрлүүлэх тухай | 2 | 0.8% | - |
| 4. | Санхүү, хяналт аудитын газар | Өмнөх оны хяналт шалгалтын дүнгийн талаарх гомдол | 1 | 0.4% | Улсын байцаагчийн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах |
| | | Төрийн байгууллагын чиг үүрэгт хамраахгүй асуудлаар ирүүлсэн гомдол | 1 | 0.4% | Өргөдөл гомдол ирүүлэхдээ байгууллагын чиг үүрэгтэй холбоотой асуудлаар ирүүлж байх |
| 5. | Цагдаагийн газар | Засгийн газрын /Иргэд олон нийттэй харилцах 1111 төв/-өөс | 1 | 0.4% | Гомдлын дагуу Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт явуулах /код 112/ журам"-ын дагуу албаны шалгалтыг зохион байгуулж алба хаагчдын буруутай үйлдэл тогтоогдсон тохиолдолд Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлд зааснаар сахилгын арга хэмжээ оногдуулж, алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй тохиолдолд албаны нэр хүндийг сэргээхэд онгцойлон анхаарч ажиллаж байна. |
| | | Алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой | 2 | 0.8% | Зөрчил гаргасан алба хаагчдыг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн төлбөртэй сургалтад хамруулах, дахин зөрчил дутагдал гаргахгүй байх баталгааг гаргуулан ажиллаж байна. |
| 6. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар | Хүүхдийн тэтгэлэгийн талаарх гомдол | 2 | 0.8% | Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлэх, шийдвэр гүйцэтгэгч нарт төлбөр төлөгч, авагч талуудад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцын талаар танилцуулж, харилцааны ёс зүйтэй байх үүрэг чиглэл өгч биелэлтэд хяналт тавих |

| | | | | | |
|-----|---------------------------------|--|------------|-------------|---|
| 7. | Эрүүл мэндийн газар | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой, үзлэг үйлчилгээг хангалтгүй үзүүлсэн. Эмнэлгийн ажилчдын харьцаа, хандлага, ёс зүйгүй, ажилчдын маргааны талаах гомдол | 3 | 1.3% | Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, эмнэлгийн ажилчдын харилцаа хандлага, ёс зүйн талаар анхаарч, алдаа дутагдалыг тухай бүр арилгах |
| 8. | Соёл, урлагийн газар | Цалин буурсантай холбоотой гомдол | 2 | 0.8% | Хавсран ажиллаж байгаа ажилчдад хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгох хэрэгтэй. Мөн ТҮ-ийн цалинг нэмж, орон нутгийн нэмэгдэл олгох, ТЗ, ТҮ хоёулаа адилхан орон нутагт ажилладаг мөртлөө ТЗ орон нутгийн нэмэгдэл аваад ТҮ орон нутгийн нэмэгдэл авдаггүй. |
| 9. | Эрүүл мэндийн даатгалын газар | Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж үйлчилгээнд Нэгдсэн эмнэлэг иргэнээс илүү төлбөр авсан гомдол | 1 | 0.4% | Гомдлыг тэр дариуд нь шийдвэрлэж, Нэгдсэн эмнэлгээс эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж үйлчилгээнд авсан илүү төлбөрөө буцаан авахыг мэдэгдсэн болно. |
| 10. | Боловсрол, шинжлэх ухааны газар | Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол | 4 | 1.7% | Боловсрол, шинжлэх ухааны газраас чиглэл өгч ажиллаж байна. |
| 11. | Аймгийн ЗДТГ | Төрийн албан хаагчийн ёс, зүй, томилгоотой холбоотой | 2 | 0.8% | Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах |
| | Нийт | | 223 | 100% | |

Иргэдээс дараах 11 чиглэлээр Архангай аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 223 гомдол гаргасан нь нийт өргөдөл, гомдлын 1.04 хувийг эзэлж байна

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН АГУУЛГА /2024 оны 1 дүгээр улирлын байдлаар/

| | |
|---|---|
| <p>Нийт хүлээн авсан санал, хүсэлт, өргөдөл, гомдлын тоо 2327</p> | <p>Архангай аймгийн хэмжээнд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 2327 хүсэлт, гомдол, санал ирсэн бөгөөд агуулгаар нь ангилан үзвэл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүсэлт - 1785 /76.7%/ 2. Санал - 23 /0.98%/ 3. Гомдол - 223 /9.58%/ 4. Мэдэгдэл - 296 /12.7%/ <p>Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 82.4% хувьтай байна.</p> <p>2023 оны 1 дүгээр улирлын тайлан мэдээтэй харьцуулан үзвэл: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан нийт өргөдөл, гомдол 45.6 хувиар буурсан, санал 93.9 хувиар буурсан дүнтэй байна.</p> <p>2024 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт өргөдөл, гомдолд дараах асуудлууд зонхилж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн албан хаагчийн томилгоо, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээ, |
|---|---|

Цалинтай ээжийн тэтгэмж үйлчилгээ, хөнгөлөлттэй эм тариа эрүүл мэндийн үйлчилгээ, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, Түлшний хөнгөлөлтийн үйлчилгээ, Насны хишиг олгох үйлчилгээнд хамрагдах, Шилжилт хөдөлгөөн, Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа авах, Газар эзэмших, шилжүүлэх, газрын зориулалт өөрчлөх болон тэтгэвэр, тэтгэмж, урамшуулал хүссэн, тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгуулах, буцалтгүй тусламж үзүүлэх, өвс тэжээл хөнгөлөлттэй үнээр авах, ажилд орох, сургалтад хамрагдах, газар олгуулах, лавлагаа шүүлгэх, ус ашиглуулах, худаг гаргах зөвшөөрөл, сургалтын төлбөрийн хөнгөлөлт авах гэх мэт хүсэлтүүд - 1785 буюу 76.7%,

2. Халамж, тэтгэмж, эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамрагдах, жил бүр зохион байгуулагддаг арга хэмжээ, үйл ажиллагаанд шинээр тусгуулах санал өгөх, төлбөрт үйлчилгээний үнэ тарифыг өөрчлүүлэх гэх мэт саналууд - 23 буюу 0.98%,

3. Газар олголт, иргэн хоорондын газар эзэмших, өмчлөх маргаан, газрын татварын маргааныг шийдвэрлүүлэх, төсөвт байгууллагын цалин хөлс, урамшуулал, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой, үзлэг үйлчилгээг хангалтгүй үзүүлсэн. Эмнэлгийн ажилчдын харьцаа, хандлага, ёс зүйгүй, ажилчдын маргаан, төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй, Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн үйл ажиллагаа, сумдын цас, зудтай холбоотой зам гаргуулах, иргэн хоорондын болон иргэн аж ахуй нэгжийн хоорондын зөрчил маргаантай холбоотой гомдол - 223 буюу 9.5%-ийг тус тус эзэлж байна.

Мөн иргэд, олон нийтэд нээлттэй 70331111 утсанд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 56 дуудлага мэдээлэл ирснээс 9 гомдол, 5 санал, 42 хүсэлт буюу мэдээлэл авах дуудлага ирсэн байна. Дуудлага мэдээллийг агуулгын хувьд авч үзвэл: Эмнэлгийн тусламж үйлчилгээ, цагдаагийн алба хаагчид гаргасан гомдол, хөдөө сумдад цас зуд ихтэй, зам гаргуулах болон төрийн байгууллага, албан тушаалтны холбогдох утасны дугаар, хаяг байршил, сумдын ЗДТГ-ын удирдлагуудын утасны дугаар, аймаг орон нутагт зохион байгуулагдаж буй арга хэмжээ, хандивын аяны мэдээ мэдээлэл авах дуудлага хувийг эзэлж байна. Шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Засгийн газрын 11-11 төвд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар Архангай аймагтай холбоотой нийт 29 гомдол, санал, хүсэлт ирсэн байна. Үүнээс 26 гомдол, 1 санал, 2 хүсэлт ирснээс: Хөдөлмөр эрхлэлтийн маргаан, цас зуданд боогдсон иргэдийн гомдолууд ихэнх хувийг эзэлж байна. Эдгээр гомдол, санал, хүсэлтүүдийг "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд албан бичгээр хүргүүлэн шийдвэрлэлтийн хариуг тухай бүр иргэдэд хүргэж ажиллаж байна. Шийдвэрлэлт 65.5 хувьтай байна.